



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 129

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1 дэх хэсгийг тус тус аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 14,112,000.00 (арван дөрвөн сая нэг зуун арван хоёр мянга) төгрөгийн балансын үнэ, 4,508,000.02 (дөрвөн сая таван зуун найман мянган төгрөг хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий авто машины граш, Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөд давхар бүртгэлтэй байгаа тул Хот тохижуулах төвийн бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Эрдэнэсүрэн болон Хот тохижуулах газрын дарга Д.Мөнхцоож нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР 